



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 396

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

“Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.4-д заасан “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно”, Сангийн сайдын 2012 оны 264 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг тус тус зөрчиж худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 80.4 сая төгрөгийн худалдан авалт хийсэн, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21.12 дахь заалтыг зөрчиж Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд 20.3 сая төгрөгийн урамшуулал олгосон зэрэг 117,1 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглэж, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 20 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн захирал Л.Эрхбаатарт дотоод хяналтыг сайжруулж, дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

2.1. Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллах;

2.2. Худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах;

2.3. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8-д заасны дагуу үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг шинээр худалдан авахдаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрийг үндэслэж, зорилтот түвшинд батлагдсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө худалдан авахгүй байх;

2.4. Монгол Улсын Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дэх заалтыг мөрдөж, гэрээгээр худалдаж авахаар тооцсон бараа материал, ажил үйлчилгээний үнээс 10 хувийн татварыг суутган тооцож, төсөвт төвлөрүүлэх;

000080

2.5. “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2018 оны 8 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах;

2.6. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдалд хяналт тавьж ажиллах үүргээ хангалтгүй биелүүлсэн холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох;

2.7. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах төлөвлөгөөний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх;

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалт

№	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Дүн /мян.төгрөг/	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй харуул хамгаалалтын ажил үйлчилгээ	Захирал Л.Эрхбаатар Ерөнхий ня-бо Ч.Орхон	80,400.00	Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаал, 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусган батлуулж, гүйцэтгэлийг тайлагнаж ажиллах,
2	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль зөрчин Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд олгосон урамшуулал	Захирал Л.Эрхбаатар Ерөнхий ня-бо Ч.Орхон	20,302.12	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.12 дах заалтыг мөрдөж ажиллах
3	Байгууллагын үйл ажиллагаатай холбоогүй үргүй зардал	Захирал Л.Эрхбаатар Ерөнхий ня-бо Ч.Орхон	8,597.20	Монгол Улсын "Төсвийн тухай хууль"- ийг мөрдөж ажиллах
4	Монгол Улсын Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу хувь хүний орлогын албан татвар ногдуулаагүй орлого	Захирал Л.Эрхбаатар Ерөнхий ня-бо Ч.Орхон	7,830.00	Монгол Улсын Хувь хүний орлогын албан татварын тухай хууль"-ийн 6 дугаар зүйлийн 6.3, дахь заалтыг мөрдөж ажиллах,
	Дүн		117,129.32	

**“ЭРДЭНЭТИЙН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК-ИЙН 2017-2018
ОНЫ САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТАЙЛАН**

2019 оны 09 дүгээр сарын 05

Улаанбаатар хот

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7.4, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 66 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 12 дугаар тогтоолоор баталсан Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд баримтын хяналт шалгалт хийх төлөвлөгөөний дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын баталсан удирдамжаар “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 он, 2018 оны оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд баримтын шалгалтыг тус хэлтсийн мэргэжилтэн, улсын ахлах байцаагч Н.Ган-Эрдэнэ, мэргэжилтэн Т.Анхбаяр нар 2019 оны 08 дугаар сарын 20-29-ний өдрүүдэд хийлээ.

Шалгалтад “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн үйлдвэрлэлт борлуулалт, санхүү, техник эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн биелэлт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, мөнгөн хөрөнгийн зарцуулалт, байгууллагын авлага, өглөгийн байдал, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай” хууль болон зохих журам, зааврын дагуу худалдан авалтыг төлөвлөн зохион байгуулж, тайлагнасан байдал, эд хөрөнгө, бараа материал, хандив тусламжийн зарцуулалт зэрэг асуудлуудыг хамруулж, холбогдох хууль тогтоомж болон бусад эрх зүйн актуудыг удирдлага болгов.

Байгууллагын мөнгөн хөрөнгийн ажил гүйлгээг 2017-2018 онд ХААН банк, Хас банк, Голомт банк, Хадгаламж банк гэсэн арилжааны 4 банкинд төгрөгийн 4 харилцах дансаар хийжээ.

Дээрх дансдын ажил гүйлгээнд нэгдүгээр гарын үсгийг Л.Эрхбаатар, хоёрдугаар гарын үсгийг санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч Ч.Орхон нар зурж ирсэн байна

ХОЁР. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ЗХУ, БНМАУ-ын Засгийн газар хоорондын 1981-1985 онд хамтран ажиллах хэлэлцээрийн дагуу Эрдэнэт хотын цахилгаан дулааны ачааллыг хангах зорилгоор тус станцыг байгуулах шийдвэр гаргажээ.

Станцыг барьж байгуулах ажлыг 1984-1990 онд ЗХУ-ын “Загранэнергострой” байгууллагын харьяа “Монгол-энергострой” трестийн “Эрдэнэтэнергострой” барилга угсралтын удирдах газар хийж гүйцэтгэсэн бөгөөд станцын анхны зуухыг 1986 оны 12 дугаар сарын 30-ны өдөр галлаж, ашиглалтад хүлээн авсан бол 1987 оны 10 дугаар

сарын 27-ны өдөр тус станц УБҮ-ийн дулааны станцтай зэрэгцэн ажиллаж, Эрдэнэт хотын хэрэглэгчдэд дулааны эрчим хүч үйлдвэрлэн түгээж эхэлсэн байна.

1990 оны 12 дугаар сарын 30-ны өдөр тус станцын барилга, байгууламж, тоног төхөөрөмжийн угсралтын ажлыг бүрэн дуусгаж, Улсын комисст төслийн хүчин чадлаар хүлээлгэн өгчээ.

Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 164 дүгээр тогтоолоор тус станцыг "Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" хувьцаат компани нэртэйгээр төрийн өмчит компани болгон зохион байгуулсан байна.

Тус компани нь цагт 36 МВт цахилгаан эрчим хүч, 302.5 Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэх чадалтай бөгөөд жилд дундажаар 100 сая кВт цахилгаан эрчим хүч, 550 мянган Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэн Эрдэнэт хотын Уулын баяжуулах үйлдвэрийн дулааны станцын хэрэглэгчдээс бусад үйлдвэр, албан байгууллагууд, орон сууцны хорооллуудыг дулаанаар хангаж, гаргасан цахилгаан эрчим хүчээ "ЭБЦДС" ТӨХК-ийн Эрдэнэт-Хархорины салбарын Эрдэнэтийн 220 кВ-ын дэд станцад нийлүүлж байна.

Тус компанид БКЗ-75-39фб маягийн 7 зуух, ПТ-12-35/10 м маягийн 1 ширхэг, Р-12-35/5 маягийн 2 ширэг трубин, Т-12-У2 маягийн 3 ширэг генератор зэрэг үндсэн тоноглолууд ажиллаж, дулаан, цахилгааны эрчим хүчийг хослон үйлдвэрлэж байна.

"Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ТӨХК нь Эрдэнэт хотын цахилгаан, дулааны ачааллыг хангах зорилгоор 8 цех, 4 хэлтэс, 1 алба нийт 437 ажиллагсадтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

**ГУРАВ. "ЭРДЭНЭТИЙН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨХК-ИЙН
2017-2018 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ,
ЗОРИЛТОТ ТҮВШИНГИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

"Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ТӨХК-ийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон их засвар, техник, зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын 2017 оны төлөвлөгөөг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 215 дугаар тогтоолоор баталсан бол 2018 оны төлөвлөгөөг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 663 дугаар тогтоолоор тус тус баталжээ.

Дулааны эрчим хүч үйлдвэрлэлийн үндсэн түүхий эдийн үнийн өсөлт болон эрх бүхий байгууллагын санал, хүсэлт, шийдвэрийн дагуу компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон их засвар, техник, зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын 2017 оны төлөвлөгөөнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 399 дүгээр тогтоолоор, 2018 оны төлөвлөгөөнд компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 25 дугаар тогтоолоор тодотгол оруулж, баталсан байна.

**КОМПАНИЙН 2017-2018 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН
ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИНГИЙН БИЕЛЭЛТ**

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 он		Өөрчлөлт		2018 он		Өөрчлөлт	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Тоо	Хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Тоо	Хувь
1	Боловсруулсан ЦЭХ	сая кВтц	157.1	162.3	5.2	3.3	156.1	163.9	7.8	5.0
	Боловсруулсан ДЭХ	мян.гКал	558.0	571.7	13.7	2.5	571.8	592.4	20.6	3.6
2	Дотоод хэрэгцээний ЦЭХ	хувь	19.7	19.4	(0.3)	(1.5)	19.6	18.9	(0.7)	(3.6)
		сая кВтц	30.9	31.5	0.6	1.9	30.6	31.0	0.4	1.3
3	Эрчим хүч түгээлт ЦЭХ	сая кВтц	126.1	130.7	4.6	3.6	125.5	132.8	7.3	5.8
	Эрчим хүч түгээлт ДЭХ	мян.гКал	530.4	543.3	12.9	2.4	545.4	567.2	21.8	4.0
4	Нийт орлого	сая төг	34,460.9	34,757.6	296.7	0.9	35,657.8	35,870.1	212.3	0.6
	Үүнээс : Борлуулалтын орлого	сая төг	34,222.3	34,372.1	149.8	0.4	35,276.6	35,366.8	90.2	0.3
5	Нийт зардал	сая төг	34,460.9	34,708.1	247.2	0.7	35,657.8	35,471.5	(186.3)	(0.5)
	Үүнээс: Удирдлагын зардал	сая төг	291.3	280.4	(10.9)	(3.7)	349.9	343.2	(6.7)	(1.9)
6	Татварын өмнөх ашиг /алдагдал /	сая төг	-	49.5	49.5			343.9	343.9	
	Цэвэр ашиг /алдагдал /	сая төг	-	49.5	49.5			343.9	343.9	
7	Бор. орлогын нэг төгрөгт ногдох зардал	төг	1.0	1.0	(0.0)	(1.0)	1.0		(1.0)	(100.0)
8	Нийт авлага	сая төг	1,637.5	1,411.8	(225.7)	(13.8)	2,371.90	2,426.70	54.8	2.3
9	Нийт өр төлбөр	сая төг	3,072.1	1,731.0	(1,341.1)	(43.7)	2,764.90	1,753.90	(1,011.0)	(36.6)
	Үүнээс : Богино хугацаат өглөг	сая төг	3,072.1	1,731.0	(1,341.1)	(43.7)	2,764.90	1,753.90	(1,011.0)	(36.6)
10	ХО, Их засвар ТЗБАХэмжээ	сая төг	3,407.9	3,224.5	(183.4)	(5.4)	4,092.40	3,572.30	(520.1)	(12.7)
11	Нийт ажиллагсдын тоо	тоо	437.0	437.0	-	-	437.0	437.0	-	-
12	Нийт цалингийн сан	сая.төг	8,247.9	8,172.2	(75.7)	(0.9)	8847.1	8,786.90	(60.2)	(0.7)

а. Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэлт, түгээлтийн талаар:

Компани 2017 онд Цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлтийн төлөвлөгөөг **5,1** сая кВтц-аар, ЦЭХ түгээлтийг **4,6** сая кВт-аар тус тус нэмэгдүүлж ажиллажээ.

Цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн төлөвлөгөө давж биелэхэд:


- ДҮТ-өөс гадна агаар хүйтэрсэнтэй холбогдуулан 2, 4, 11 дүгээр саруудад цахилгааны ачааллын горимыг нэмэгдүүлж өгснөөс хамааран **2,4** сая кВтц,
- 10 дугаар сард ТЭЦ-4 ТӨХК-ийн 1 турбин зогсож, ДҮТ-өөс 12 хоног цахилгааны ачааллыг нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор цахилгааны эрчим хүчний үйлдвэрлэл **2,7** сая кВтц-аар нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Харин 2018 онд **156.1** сая.кВтц ЦЭХ боловсруулж, **125.5** сая.кВтц ЦЭХ түгээх төлөвлөгөөтэй ажилласнаас гүйцэтгэлээр **163.9** сая.кВтц цахилгаан эрчим хүч боловсруулан үйлдвэрлэлийн төлөвлөгөөг **7.3** сая.кВтц буюу **5.0%-иар**, **132.8** сая.кВтц цахилгаан түгээж, түгээлтийн төлөвлөгөөг **7.3** сая.кВтц-аар буюу **105.8 %-иар** биелүүлсэн байна.

6. Дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, түгээлтийн талаар: 2017 онд 571.1 мян.Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэж, төлөвлөгөөг 13,7 мян.Гкал буюу 2,4 %-иар, 543,3 мян.Гкал дулааны эрчим хүч түгээж, түгээлтийн төлөвлөгөөг 13,0 мян.Гкал буюу 2,4%-иар тус тус давуулан биелүүлсэн бол 2018 онд 545.4 мянган Гкал дулаан түгээхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 567.2 мянган Гкал дулаан түгээж төлөвлөгөөг 7.3 мян.Гкал буюу 4.0%-иар давуулан биелүүлсэн байна. 2018 онд өмнөх оноос түгээсэн цахилгаан эрчим хүч 2.1 мян.Гкал буюу 1.6 хувиар, түгээсэн дулааны эрчим хүч 23.9 мян.Гкал буюу 4.4 хувиар илүү байна.

Борлуулалтын орлого: Компани 2017 онд 34,460.9 сая төгрөгний орлоготой ажиллахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 34757,5 сая төгрөгний орлоготой ажиллажээ. Үүнээс цэвэр борлуулалтын орлого 149.7 сая төгрөгөөр, үйл ажиллагааны бус орлого 146.9 сая төгрөгөөр нэмэгдсэн давж биелсэн байна. 2017 онд цэвэр борлуулалтын орлого давж биелэхэд ЦЭХ-ний түгээлт, тариф нэмэгдэл (136.5 сая төгрөг), ДЭХ-ний нэмэлт ус болон хэрэглээний нэмэгдэл (13,2 сая төгрөг) нөлөөлсөн байна.

2018 онд 35,657.8 сая төгрөгийн орлоготой ажиллахаар төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 35,870.1 сая төгрөгийн орлоготой ажиллаж, орлогын төлөвлөгөөг 212.2 сая төгрөгөөр давуулан биелүүлэв. Үүнээс цэвэр борлуулалтын орлого 90.2 сая төгрөгөөр, үйл ажиллагааны бус орлого 122.0 сая төгрөгөөр нэмэгдсэн. Нийт орлого өмнөх оноос 1,112.5 сая төгрөг буюу 3.2 хувиар нэмэгдсэн байна. Нийт өсөлтийн 70.2 хувийг ЦЭХ-ний орлогын өсөлт эзэлж байна.



Нийт зардал: Компани 2017 онд 34,707.9 сая төгрөгийг зардал гаргаж, батлагдсан төлөвлөгөөг 0.7 хувь буюу 247.2 сая төгрөгөөр хэтрүүлсэн бол 2018 онд 35,471.5 сая төгрөгийн зардал гаргаж батлагдсан төсвийг 0.5 хувь буюу зарцуулж, 186.3 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.

2018 онд удирдлагын зардалд 349.9 сая төгрөг төлөвлөснөөс 343.2 сая төгрөг зарцуулж, 6.7 сая төгрөгийн хэмнэлт гаргасан байна.

**Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2017-2018
оны зардлын гүйцэтгэл**

№	Үзүүлэлт	2017 он гүйцэтгэл	2018 он		Өөрчлөлт төлөвлөгөөнөөс		Өөрчлөлт өмнөх оноос	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Тоо	Хувь	Тоо	Хувь
1	Цалин	8,018.55	8,653.94	8,593.82	-60.13	-0.69	575.27	7.2
2	НДШ	1,036.30	1,211.55	1,202.80	-8.75	-0.72	166.50	16.1
3	Түлшний зардал	14,578.06	14,436.31	14,421.09	-15.21	-0.11	-156.96	-1.1
4	Цахилгаан	9.86	7.30	7.19	-0.11	-1.48	-2.68	-27.1
5	туслах материал	89.31	128.68	125.98	-2.70	-2.10	36.66	41.1
5	шатахуун	360.37	469.50	467.00	-2.51	-0.53	106.63	29.6
7	Сэлбэг, урсгал зардал	463.78	589.31	588.13	-1.19	-0.20	124.34	26.8
8	Ус	1,429.55	1,679.25	1,655.82	-23.43	-1.40	226.26	15.8
9	Томилолт	14.65	14.65	13.98	-0.67	-4.57	-0.67	-4.6
10	Бичиг хэрэг	24.51	27.23	26.32	-0.91	-3.34	1.81	7.4
11	Холбоо	14.32	15.10	14.93	-0.17	-1.12	0.61	4.2
12	Хөд.хамгаалал	146.93	154.89	147.64	-7.25	-4.68	0.72	0.5
13	Гал команд	18.27	18.99	18.92	-0.07	-0.38	0.65	3.5
14	Харуул хамгаалалт	145.29	146.18	146.18	0.00	0.00	0.89	0.6
15	Элэгдэл	4,440.78	3,835.69	3,816.72	-18.97	-0.49	-624.06	-14.1
16	Удирдлага	280.40	349.69	343.24	-6.45	-1.84	62.84	22.4
17	Зар сурталчилгаа	13.41	10.00	9.73	-0.27	-2.73	-3.68	-27.4
18	Цах. түгээлт.алдагд	185.15	190.25	191.36	1.11	0.58	6.21	3.4
19	сургалт	87.42	81.54	78.36	-3.17	-3.89	-9.05	-10.4
20	Ашиглалтын цахилгаан	56.10	49.35	44.19	-5.17	-10.47	-11.91	-21.2
21	Борлуулалтын шимтгэл	1,878.53	1,961.22	1,960.75	-0.46	-0.02	82.23	4.4
22	Усны нөөц ашиглалтын төлбөр	93.04	129.64	128.38	-1.26	-0.97	35.33	38.0
23	Банкны үйл-ний хөлс	0.2554	0.35	0.3391	-0.01	-3.11	0.08	32.8
24	Гишүүнчлэл, үнэт цаас	3.45	3.50	0.884	-2.62	-74.74	-2.56	-74.4
25	Газрын төлбөр	35.79	35.82	35.82	0.00	0.00	0.03	0.1
26	Үл хөдл хөр	103.07	107.30	107.30	0.00	0.00	4.22	4.1
27	Автын татвар, даатгал	8.21	9.17	9.17	0.00	0.00	0.96	11.7
28	Аудит	18.18	42.94	42.94	0.00	0.00	24.75	136.2
29	ЭХЗХ	154.08	153.88	153.88	0.00	0.00	-0.20	-0.1
30	Бүгд	33,707.62	34,513.23	34,352.85	-160.38	-0.46	645.23	1.9
31	АНЗ	774.72	931.03	928.29	-2.74	-0.29	153.57	19.8
	НИЙТ	34,482.34	35,444.26	35,281.14	-163.12	-0.46	798.80	2.3

2018 онд төлөвлөсөн 31 зардлаас 1 төрлийн зардлыг төлөвлөгөөс 1,1 сая төгрөгөөр хэтрүүлж, бусад зардлыг хэмнэж ажилласан байна.

Орон тоо, цалин хөлс: Тайлант хугацаанд компани 1 албан, 5 хэлтэс 8 цехийн зохион байгуулалттай, 437 ажиллагсадтай үйл ажиллагаа явуулж, 35,366.8 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж борлуулснаас нэг ажилтны дундаж бүтээмж 80,931.0 мян.төг, үүнээс үндсэн үйлдвэрлэлийн нэг ажилтаны хөдөлмөрийн бүтээмж 110,867.8 мян.төг болж, өмнөх оны мөн үеийн үйлдвэрлэлийн ажилтны бүтээмжээс 5,107.3 мян.төгрөгөөр нэмэгдсэн.

Нийт ажиллагсдаас удирдах ажилтан 4, ИТА албан хаагч 114, ажилчид ба бага тушаалын ажилтан 319, өмнөх оны мөн үеийн орон тоонд өөрчлөлт ороогүй. Ажиллагсдын дундаж цалин 1,517,857 төгрөг, жилийн үр дүнгийн шагналыг оруулан тооцсон дундаж цалин 1,675,577 төгрөг байна.

Тайлант хугацаанд цалингийн зардалд төлөвлөгөөгөөр 8,847.1 сая төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 8,786.7 сая төгрөг зарцуулж, гүйцэтгэлийн хувь 99,3% буюу 60,4 сая төгрөгийн хэмнэлттэй гарсан. 2018 оны 01 сарын 01-ээс 5%-иар нэмэгдүүлэн мөрдөж байгаад 2018 оны 12-р сарын 20-нд төлөвлөгөөнд тодотгол хийн 2018 оны 12 сарын 01-ээс цалингийн итгэлцүүрийг зассан нь дунджаар 19%-иар цалинг нэмэгдүүлсэн.

Түлшний зардал: 14,436.3 сая төгрөг төлөвлөж, 14,421.1 сая төгрөг зарцуулж, 15.2 сая төгрөг хэмнэсэн.

Оны эхэнд 22.3 мянган тонн нүүрсний үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант хугацаанд 328.3 мян.тн нүүрс уурхайнуудаас авч үйлдвэрлэлд 318.4 мян.тн, бусад хэрэглээнд мян.тн нүүрс зарцуулж 2018 оны эцэст үлдэгдэл 23,5 мян тн-ийн үлдэгдэлтэй гарсан байна.

Усны зардал: 1679,3 сая төгрөг зарцуулсан нь төлөвлөснөөс 23,4 сая төгрөг хэмнэсэн.

№	Төрөл	2017 Гүйц	2018 төл	2018 гүйц	Зөрүү
1	Цэвэр ус:				
	Технологийн хэрэгцээ	1035.9	1260	1254.06	-5.9
	нэгж үнэ	1250	1250	1250	0
	бүгд үнэ мян.төг	1,294,877.50	1,575,000.00	1,567,570.00	(7,430.00)
	суурь хураамж	3,412.80	3,412.80	3,412.80	-
	ГОК-д төлөх нийт зардал	1,298,290.30	1,578,412.80	1,570,982.80	(7,430.00)
2	Ахуйн хэрэгцээний	65.2	50	41.94	-8.1
	нэгж үнэ	1,250.00	1,250.00	1,250.00	-
	бүгд үнэ мян.төг	81,448.80	62,500.00	52,430.00	(10,070.00)
	суурь хураамж	836.2	836.2	944.2	108
	Бохир ус	65.2	50	41.94	-8.1
	нэгж үнэ	750		750	0
	бүгд үнэ мян.төг	48869.3	37500	31458	-6042
	Орон сууцанд төлөх нийт зардал	131,154.20	100,836.20	84,832.20	(16,004.00)
	Усны зардал	1,429,553.80	1,679,249.00	1,655,815.00	(23,434.00)

Туслах материалын зардал: Химийн туслах материалд 128.7 сая төгрөг төлөвлөснөөс 125.9 сая.төг зарцуулж 2.7 сая.төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.

- Фосфат 2,5 тн төлөвлөснөөс 2,425 тн-ыг хэрэглэж 465,73 мянган төгрөгний хэмнэлт гарсан нь фосфатыг 3400 мянган төгрөгөөр авахаар төлөвлөсөн ч гаднаас 3313,1 мян төгрөгөөр худалдаж авсан, мөн тэжээлийн усны зарцуулалт өмнөх жилийнхээс харьцангуй бага байсан зэрэг нөлөөлсөн байна.
- Давсыг 108 тн төлөвлөж 106 тн хэрэглэж 756,42 мян.төг-ний хэмнэлттэй ажилласан нь төлөвлөлтийн үнээс бага зэрэг хямд үнээр давс авсан, боловсруулж байгаа үүсгэвэр усны хатуулаг төлөвлөснөөс бага байсан болон катионит шүүлтүүрүүдэд шинээр шүүгч материал нэмж ачаалласан нь шингээх багтаамжийг нэмэгдүүлж давсны хувийн зарцуулалтыг багасгаж давс хэмнэх нөхцөл болсон.


- Шохой 170 тн хэрэглэхээр төлөвлөж 165.485 тн зарцуулан 1259,26 мян.төг хэмнэлттэй гарсан нь боловсруулж буй усны хатуулаг төлөвлөснөөс бага байсан, зах зээлээс хямд шохой авч хэрэглэсэн зэргээс хэмнэгдсэн.

Ажиллагсдын нийгмийн зардал. 931.7 сая төгрөг төлөвлөж, 928.3 сая төгрөг зарцуулж 2.7 сая төгрөгөөр хэмнэгдсэн.

- Тайлангийн хугацаанд өндөр насны тэтгэвэрт 23 ажилтан, өөрийн хүсэлтээр 16 ажилтан, захиргааны шийдвэрээр 5 ажилтан тус тус ажлаас чөлөөлөгдөж, 33 хүн шинээр ажилд орсны 3 нь жирэмсний амралт дууссан ажилтан бөгөөд гэрээт ажилтан 1, 36 нь дээд боловсролтой, 15 нь бүрэн дунд боловсролтой.

2018 оны 4-р улирал

№	Зардлын төрөл	Өмнөх оны мөн үе		Тайлант үеийн		Зөрүү
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Ажиллагсдын хоолны хөнгөлөлт /НДШ-ийн хамт/	150,075.6	129,606.9	163,597.8	161,826.1	(1,771.7)
2	Ажиллагсдын түлшний хөнгөлөлт	10,647.8	10,564.5	10,872.7	10,872.7	-
3	Ажиллагсдын унааны хөнгөлөлт	6,471.6	4,859.6	4,550.0	4,518.7	(31.3)
4	Ажиллагсдад олгосон тусламж,тэтгэмж, нөхөн олговор	305,906.0	299,798.8	593,979.1	594,099.6	120.5
5	Эрүүл мэндийн үзлэг, эмчилгээ, сувилгааны зардал	42,937.0	31,430.1	47,450.0	47,309.5	(140.5)
6	Ажиллагсдад олгосон шагнал урамшуулал	67,281.1	67,313.6	86,582.7	86,513.8	(68.9)
7	Урлаг, спорт, олон нийтийн арга хэмжээний зардал	90,520.0	81,280.0	24,000.0	23,149.5	(850.5)
8	Баяр ёслолын арга хэмжээний зардал	150,000.0	149,866.0			-
	ДҮН	823,839.1	774,719.5	931,032.3	928,289.9	(2,742.4)



Нийт зардлын:

- 40,9%-ийг түлшний зардал
- 24,4%-ийг цалингийн,
- 10,8%-ийн элэгдэл,
- 5,6%-ийг борлуулалтын шимтгэл,
- 4,7%-ийг усны зардал,
- 3,4%-ийг НДШ,
- 2,6%-ийг АНЗ
- 1,7%-ийг сэлбэг, урсгал засвар,
- 1,3%-ийг шатахуун,
- 1,0%-ийг удирдлагын зардал эзэлж байна.

Ашиг, алдагдал: 2017 онд мөрдөж байгаа үнээр тооцоход нийт 34757,5 сая төгрөгийн бүтээгдэхүүн борлуулж, 34709.9 сая төгрөгийн зардал зарцуулж, 49.4 сая төгрөгийн ашигтай ажилласан бол 2018 онд 343,9 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Нийт өр төлбөр: 2017 оны гүйцэтгэлээр өглөг 1731,01 сая төгрөг байх ба зорилтот түвшингийн үзүүлэлтээс өглөг 1341,1 сая төгрөгөөр буурчээ. 2018 онд 1753,9 сая төгрөг болж, зорилтоос 1011,0 сая төгрөгөөр буурсан.

Өглөг	Зорилтот түвшин	Тайлангийн эцэст	Зөрүү	
			Тоо	хувь
Дансны өглөг	1,134.90	170.40	(964.50)	9.70
Урьдчилж орсон Орлого	1,630.00	1,583.50	(46.50)	90.30
Бүгд	2,764.90	1,753.90	(1,011.00)	100.00

Нийт авлага: 2017 оны гүйцэтгэлээр авлага 1411,7 сая төгрөг болж, зорилтот түвшингийн үзүүлэлтээс 225,7 сая төгрөгөөр буурч гарсан бол 2018 онд 2426,7 сая төгрөг болж, зорилтот түвшингээс 54,8 сая төгрөгөөр нэмэгдсэн. Тэг үлдэгдэлтэй орлогын нэгдсэн данснаас авах цахилгаан эрчим хүчний авлага оны эхнээс 912,8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь авлага нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

Авлага	Зорилтот түвшин	Тайлангийн эцэст	Зөрүү	
			Тоо	хувь
ЦЭХ	1,985.00	2,142.80	157.8	88.3
ДЭХ	229.60	150.20	-79.4	6.2
Хувь хүмүүс	7.30	5.10	-2.2	0.2
Дансны авлага	150.00	128.60	-21.4	5.3
Бүгд	2,371.90	2,426.70	54.8	100

Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалт: “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК нь худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийг холбогдох журмын дагуу боловсруулж, тайлагнасан байна. Компанийн 2017 оны Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд Хөрөнгө оруулалтаар 43 зүйлийн 949,570.0 мянган төгрөгийн бараа, Техник зохион байгуулалтын арга хэмжэнд 11 зүйлийн 98,900.0 төгрөгийн ажил, Их, урсгал засварын сэлбэг материалд 86 зүйлийн 1,906,007.8 төгрөгийн бараа, ажил үйлчилгээнд 12 зүйлийн 1,546,798.5 төгрөгийн ажил, нийт 4,501,276.3 төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг өөрийн хөрөнгөөр худалдан авахаар төлөвлөжээ.

2018 оны эцсийн байдлаар Хөрөнгө оруулалтанд төлөвлөгдсөн 41 зүйлийн барааг 485,156.7 мянган төгрөгөөр, техник зохион байгуулалтын арга хэмжээнд төлөвлөгдсөн 10 зүйлийн ажлыг 83,0216.2 төгрөгөөр, их, урсгал засварын сэлбэг материалд төлөвлөгдсөн 85 зүйлийн барааг 1,635,989.4 мянган төгрөгөөр, ажил үйлчилгээнд төлөвлөгдсөн 11 зүйлийн ажлыг 1,290,419.4 төгрөгөөр тус тус худалдан

авсны дээр Эрчим хүчний зохицуулах хорооны нэмэлт санхүүжилт болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрээр 8 төрлийн ажил, барааг 517,000.0 мянган төгрөгөөр худалдан авахаар төлөвлөгөөнд тодотгол хийсний дагуу 497,116.3 төгрөгөөр худалдан авсан байна.

Ингэснээр 2017 онд нийт худалдан авалтын дүн 3,991,703.4 төгрөг болж компанийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөний биелэлт 98,05%-ийн гүйцэтгэлтэйгээр хийгджээ.

Компани 2018 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд их засварын ажилд 23 зүйлийн 1,854,300.0 мянган төгрөгийн ажил, ТЗБАХ-д 15 зүйлийн 578,720.0 төгрөгийн ажил, хөрөнгө оруулалтанд 46 зүйлийн 1,084,800.0 мянган төгрөгийн бараа, их, урсгал засварын сэлбэг материалд 47 зүйлийн 1,990,860.0 мянган төгрөгийн сэлбэг материал, нийт 5,508,680.0 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг өөрийн хөрөнгөөр худалдан авахаар төлөвлөж, тайлант оны эцэст төлөвлөгөөний биелэлт 98,5 %-ийн гүйцэтгэлтэйгээр хийгдсэн байна.

Шалгалтад хамрах хугацаанд компанийн худалдан авалттай холбоотой ямар нэг гомдол, маргаан гараагүй байна. Түүнчлэн худалдан авалтын тендерийн материалыг Сангийн сайдын тушаалаар батлагдсан журам зааврын дагуу цэгцэлж, хавтасласан нь шинэлэг ажил болсон байна.

Дөрөв. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын талаар

“Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 он, 2018 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт **117,129.32** мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

4.1. Худалдан авалттай холбоотой зөрчил, дутагдал

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгалгүй хэрэгжүүлсэн ажил, үйлчилгээ: “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК-аас нь 2017-2018 онуудад компанийн харуул, хамгаалалтын **80,400.0** мянган төгрөгийн ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусган батлуулаагүй байна. Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаал, 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг зөрчсөн байна.

№	Зардлын нэр	Зардлын дүн /мян.төг/	Гүйцэтгэгч
2018	Гэрээт харуул хамгаалалтын зардал	80,400.00	Бамбай-Уул ХХК
	2018 оны дүн	80,400.00	

4.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд олгосон хууль бус урамшуулал: Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2017-2018 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар шагнал, урамшууллын зардлын зарцуулалтыг шалгахад тус компани Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.12 дахь заалтыг зөрчин компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн төлөөлөл хэрэгжүүлж буй төрийн албан хаагч нарт 2016 оны үр дүнгээр 2017 оны 2 дугаар сарын 08-нд 7,840.0 мянган төгрөг, 2017 оны үр дүнгээр 2018 оны 2 дугаар сард 6,206.7 мянган төгрөг, 2018 оны үр дүнгээр 2019 оны 1 дүгээр сарын 29-нд 6,255.5 сая төгрөг бүгд **20,302.1** мянган төгрөгийг олгосон байна.

**ЭДЦСтанц ТӨХК-ны ТУЗ-н гишүүдийн 2016 оны жилийн үр дүнгийн
шагналт цалин**

			/төгрөг/
Нэр	Урамшил бодох дундаж цалин	Олговол зохих сар	Олговол зохих дүн
М. Ангараг	300,000.00	4	1,200,000.00
Ж. Жанарбаатар	280,000.00	4	1,120,000.00
Лхагвасүрэн	280,000.00	4	1,120,000.00
М. Дондогдорж	280,000.00	4	1,120,000.00
Д. Одмаа	280,000.00	4	1,120,000.00
Б. Мөнх-Очир	280,000.00	4	1,120,000.00
С. Жамъянжав	260,000.00	4	1,040,000.00
Дүн	1,960,000.00		7,840,000.00

**ЭДЦСтанц ТӨХК-ны ТУЗ-н гишүүдийн 2017 оны жилийн үр дүнгийн
шагналт цалин**

			/төгрөг/
Нэр	Урамшил бодох дундаж цалин	Олговол зохих сар	Олговол зохих дүн
М. Ангараг	300,000.00	3.5	1,050,000.00
Ж. Жанарбаатар	280,000.00	3.5	980,000.00
Лхагвасүрэн	280,000.00	3.5	980,000.00
М. Дондогдорж	280,000.00	3.5	980,000.00
Д. Одмаа	280,000.00	3.5	980,000.00
Б. Мөнх-Очир	93,333.30	3.5	326,666.70
С. Жамъянжав	260,000.00	3.5	910,000.00
Дүн	2,730,000.00		6,206,666.70

**ЭДЦСтанц ТӨХК-ны ТУЗ-н гишүүдийн 2017 оны жилийн үр дүнгийн
шагналт цалин**

			/төгрөг/
Гишүүдийн нэр 2019.1.29	Урамшил бодох дундаж цалин	Олговол зохих сар	Олговол зохих дүн
Л.Ерэн-Өлзий	254,545.45	3.5	890,909.09
Ж.Жанарбаатар	414,545.45	3.5	1,450,909.09
Б.Баясгаланбаатар	241,818.18	3.5	846,363.64
Ж.Гэрэл	34,545.45	3.5	120,909.09
Б.Ариунтунгалаг	34,545.45	3.5	120,909.09
Д.Одмаа	414,545.45	3.5	1,450,909.09
Т.Бадамгэрэл	392,727.27	3.5	1,374,545.45
	2,858,182	3.5	6,255,454.55

Нийт дүн 20,302.1 мянган төгрөг

4.3. Байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоогүй гарсан үргүй зардал: Баримтын шалгалтаар касс, харилцахын баримт шалгахад байгууллагын эрх захирагчаас төсвийн талаар хэрэгжүүлэх “Төсвийн тухай хууль”-ийн 6.4.1-д заасан “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.2-д заасан “Төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх” тухай заалтыг зөрчиж, байгууллагын үндсэн үйл ажиллагаатай төдийлөн холбоогүй хавсралтад дурдсан **45,327.60** мянган төгрөгийн үргүй зардал, арга хэмжээг санхүүжүүлж, өртөг зардлыг нэмэгдүүлсэн байна.

№	Огноо	Гүйлгээний утга	Зарлага
1	1/19/2017	Тушаал Б/18 Ном хуруулах Урамшуулал	656.0
2	6/6/2017	Дамжуулах сүлжээний 50н жилийн ойд	1,500.0
		2017 оны Дүн	2,156.0
1	3/9/2018	Тэмцээний оролцооны мөнгө Төрийн банк хамтарсан	500.0
4	8/1/2018	Төвийн бүсийн Их хурд наадамд гэр барих ү/а	958.7
6	8/22/2018	ДЦС-3 ТӨХК, ДЦС-4 ТӨХК-ийн 50,35 жилийн ойд шагнал	3,000.0
7	8/23/2018	Шагнал Б/182 Эрдэнэт өртөөний 40 жилийн ой	630.0
8	9/4/2018	Шагнал Б/194 ДЦС-3 50-н жилийн ой тохиолдуулан	540.0
9	9/18/2018	Аврагч-2018 тэмцээний шаардлагатай зардал	812.5
		2018 оны Дүн	6,441.2
		Нийт дүн	8,597,2

4.5. Хуулийн дагуу хувь хүний орлогын албан татвар ногдуулаагүй орлого: Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2017-2018 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар харилцахын баримт шалгахад компанийн ажилтнуудад олгосон тусламжийн орлогод Монгол Улсын хувь хүний орлогын албан татварын хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, дахь заалтыг зөрчиж **7,830.0** мянган төгрөгийн орлогод татвар ногдуулаагүй байна.

№	Огноо	Утга	Дүн
1	2017/01/18	Буцалтгүй тусламж Оюунтулга	300.00
2	2017/04/03	Буцалтгүй тусламж Тушаал №Б/78 Б.Болд	300.00
3	2017/05/26	Б.Т №120 Хишигдаваа хүү хуримын ёслол	300.00
4	2017/06/02	Б.Т Б/124 Тунгалагтуяа	580.00
5	2017/06/22	Б.Т Б/133 Мөнх-Очир	600.00
6	2017/07/04	Б.Т Б/148	300.00
7	2017/07/05	Б.Т Б/143 Доржийн Цогтбаяр хурим	300.00
8	2017/08/04	Б.Т Б/160 Ж. Отгонхүү	150.00
9	2017/08/18	Б.Т Б/171 Ганбатын Одхүү	300.00
10	2017/09/26	Б.Т Б/194 Зуухан цехийн засварчин Д. Дамба	300.00
11	2017/10/10	Б.Т Б/211 ТДамжуулах цехийн Ш. Баянмөнх	300.00
12	2017/11/20	Б.Т зуухан цехийн И. Нямдэлгэр	300.00
13	2018/01/25	Б.Т Б/24 О. Ганбаатар	300.00
14	2018/03/20	Б.Т Б/53 Э. Төмөр-Очир	300.00
15	2018/04/04	Б.Т Б/69 П. Ганбат, Т. Цэдэнсодном	600.00
16	2018/04/23	Б.Т Б/81 Д. Батхишиг	300.00
17	2018/05/01	Б.Т Б/75	300.00
18	2018/05/14	Б.Т Б/98 И. Ганболд	500.00
19	2018/06/19	Б.Т Б/125 Д. Чинбат	300.00
20	2018/07/03	Б.Т Б/142 В. Батхүү	300.00
21	2018/07/04	Б.Т Б/143 З. Пүрэвдорж	300.00
22	2018/09/25	Б.Т Б/212 ТДЦехийн Г. Баасанжаргал	300.00
23	2018/10/19	Буцалтгүй тусламж /Тушаал 234 /	300.00
		Дүн	7,830.0

ТАВ. ДҮГНЭЛТ, САНАЛ ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР

“Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК 2017 он, 2018 онд Эрдэнэт хотын цахилгаан, дулааны ачааллыг найдвартай хангах зорилтоо бүрэн хэрэгжүүлж, цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлтийн төлөвлөгөөг **5,1-7,8** сая кВтц-аар, ЦЭХ түгээлтийг **4,6-7,3** сая кВт-аар, дулааны эрчим хүч түгээлтийн төлөвлөгөөг 13,0-21,8 мян.Гкал тус тус нэмэгдүүлж, орлогын төлөвлөгөөг 0,9-0,6 хувиар давуулан биелүүлсэн байна.

2017 онд ашгийн төлөвлөгөөг 49,5 сая төгрөг, 2018 онд 343,9 сая төгрөгөөр тус тус давуулан биелүүлжээ. 2017-2018 оны зорилтот түвшингийн үндсэн үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажилласан байна.

“Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 он, 2018 оны санхүүгийн баримтад хийсэн шалгалтаар **117,129.32** мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Цаашид байгууллагын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, үргүй зардлыг арилгах, хөрөнгийн өгөөжийг сайжруулах, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хууль, журмын дагуу төлөвлөх, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах асуудалд онцгой анхаарч шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

1. Худалдан авах ажиллагаанд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль, Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах;

2. Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 8 дугаар тогтоолын 2.2-д төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс дээд шатны байгууллага, төрийн захиргааны байгууллагын зардлыг санхүүжүүлэхийг таслан зогсоох, зөрчсөн албан тушаалтанд хуулийн хүрээнд арга хэмжээ авч байхаар заасныг мөрдөж ажиллах,

3. Гадаад болон дотоод албан томилолтын хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах,

4. Санхүүгийн үйл ажиллагаанд “Төсвийн тухай хууль”-ийн 6.4.1-д заасан “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.2-д заасан

"Төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх" зарчмыг мөрдөж ажиллах,

5. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах төлөвлөгөө боловсруулан ажиллаж, биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд ТӨБЗГ-т ирүүлэх

Танилцсан:



А.Дагвадорж
/Дэд дарга/

Хянасан:

В. 3812
2019. 10.13


Ц.Түвшинзаяа
/Төрийн өмчийн бүртгэл, хяналтын
хэлтсийн дарга, Улсын ахлах байцаагч/

Ө.Батбаатар
/Төрийн өмчийн бүртгэл, хяналтын
хэлтсийн ахлах мэргэжилтэн,
Улсын ахлах байцаагч/



Тайлан
боловсруулсан:

4.7 /


Н.Ган-Эрдэнэ
/Төрийн өмчийн бүртгэл, хяналтын
хэлтсийн мэргэжилтэн, Улсын ахлах байцаагч/

Т.Анхбаяр
/Төрийн өмчийн бүртгэл, хяналтын
хэлтсийн мэргэжилтэн/

Зөвшөөрсөн:

Л.Эрхбаатар
/"Эрдэнэтийн дулааны цахилгаан станц/
ТӨХК-ийн захирал

Ч.Орхон
/"Эрдэнэтийн дулааны цахилгаан станц/
ТӨХК-ийн санхүүгийн албаны дарга -
бөгөөд ерөнхий нягтлан бодогч/